

Манмин Мэдээ

№ 68 2019 оны 1 сарын 27

Африкийг сэрээж буй Кения Найроби Манмин чуулган байгуулагдсаны 18жилийн ойн мөргөл ба баярын үйл ажиллагаа



Африк даяар авралын зар тараахад чухал үндсэн үүрэг гүйцэтгэж буй Кения Найроби Манмин чуулган нь 2018оны 11-р сарын 18нд чуулган байгуулагдсан 18жилийн ойн мөргөлийг өргөлөө. 3000-д итгэгч нар цугласан энэ өдрийн баярын мөргөлд Африк төдийгүй 8улс орноос Манмин салбар болон хамтарсан цуглааны номлогч нар, доктор, өмгөөлөгч, цагдаагын байгууллагын зочид, бизнесийн зэрэг төрөл бүрийн зочдоор дүүрэн байлаа.

Энэ удаагийн ойн баярын үйл ажиллагаа нь өмнөх жилүүдийнхээс илүүтэй бүх итгэгч нар илүү нэгдэж, баяр хөөр ба талархалтайгаар уг ойн баяртаа бэлдэж, энэ өдөр Эзэний өдрийн

их мөргөлийн үеэр Найроби Манмин чуулганы залуучуудийн бүлгийн онцгой дуу болон ариун хоор дууны баг Бурханыг магтан дуулж, алдрыг өргөлөө.

Израйль дах авралын зар түгээх үйл явдал зэрэг бүх дэлхийн даяарх олон хүмүүсийг Эзэний өвөр рүү хөтлөн буй талаарх сүмийн ивээл дүүрэн мэдээ болох Манмин теле сэтгүүл үзүүлсэний дараа уг чуулганы хариуцагч пастор Жон Мёон Ху пастор (Есүсийн Африк дахь ариун урсгалийн чуулганы ерөнхий удирдагч) нь “Бурхан Аавын алдар” гэсэн сэдвээр И Жей руг тэргүүн пастороор дамжуулан илчлэгдэх Бурханы гайхалтай хүч нөлөө болон Манмины үйлчлэлийн тухай дамжуулсан юм.

Үдээс хойш ойн баярын цуглаанд Дорно Африкийн Авралын зар тараах холбооны ерөнхий удирдагч, Кения бүгд найрамдах улсын ерөнхийлөгч асан Китонга пастор (Ридим Гаспел чуулганы хариуцагч) “Удахгүй ирэх Эзэнийг ширтэн хар” гэсэн сэдвээр сургааль айлдсан юм. Китонга пастор нь “И Жей руг пасторын зөвт байдлын Эзэний боол бөгөөд Манмин төв чуулган бол бүх даяарх чуулгануудын тэргүүлэгч, үлгэр жишээ чуулган юм.” гэж айлдан оролцогч итгэгч нарт ивээлийг дүүргэн өгч байлаа.

Түүнчлэн 18н жилийн ойн баярын өмнөх баярын тоглолт нь 11-р сарын 16ний өдөр баасан гаригийн оройн мөргөлийн 2-р хэсэгт баг бүлэг тус

бүрийн онцгой дуу болон (Дей Стар Их сургууль)-н Хелээн доктор онцгой магтан дуу оролцогчдод ойн баярын онцгой сэтгэгдэл төрүүлсэн юм. 11-р сарын 17ны өдөр Африк болон Кения Манмин чуулганы номлогчдын уулзалтанд Жон Мёон ху пастор ‘Чуулган ба Эзэний боол’ гэсэн сэдвээр Эзэний боолын гол ухагдахуун, болон сүм чуулганы ажил үйлчлэлийн тухай сэдвээр семинар сургалт явуулсан юм.

18н жилийн турш Африкт амийн сургааль ба эрх мэдэлт хүч нөлөөгөөр үй олон Эзэний боолууд итгэгч нар аврал ба ерөөлийн замаар удирдан өгсөн Ариун Гурвал Бурхандаа бүх л талархал ба алдрыг өргөө.

Бурханы эрх мэдэлт хүчээр бүх дэлхийд илчлэгдэх хэл, сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан авралын зар



Дэлхийн өнцөг булан бүрт хэл, сонсголын бэрхшээлтэй итгэгч нар ариун сайн мэдээ, эрх мэдэлт хүч нөлөөг мэдэрч, энэ төрлийн иргэдэд авралын зар түгээх ажил дэлхийн хэмжээний болтол өргөжиж байна. Энэ нь үй олон хэл, сонсголын бэрхшээлтэй итгэгч нар И Жей руг тэргүүн пасторын залбирал авах юм уу, эсвэл залбирал хийж өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-р залбирал авсаны дараа сонсголтой болсон гайхамшигт эрх мэдэлт хүчийг мэдэрснээр тэд бусаддаа маш идэвхитэйгээр дамжуулж байгаа юм (Зураг 2).

Мөн төдийгүй манай чуулганы Эзэний өдрийн Хүндэтгэлийн мөргөлүүд, Баасан гаригийн оройн мөргөл, Даниел залбирлын цагыг дэлгэцээр (NEFSIS) сайтаар дэлхийн хаанаас ч шууд хүлээн авах боломжтой бөгөөд (Зураг 1), Фейсбүүк зэрэг төрөлбүрийн социал медиа сувгаар

уг мөргөл, залбиралд оролцдог байна.

Хамрах хүрээ нь Ази төдийгүй Европ, Африк, Хойд болон Өмнөд Америк хүртэл нийт 13улс орны 500гаад итгэгч нар оролцдог болсон юм. Мөн 3н улсын 12Манмин салбар сүм (Малайзд 6сүм, Тайландад 5сүм, Латвид 1сүм), 10улсын 12гэр цуглаан (Хятад 3сүм, Дани, Перу Чед, Франц, Герман, Австри, Румин, АНУ, Урагвай, Кана) зэрэг өдрөөс өдөрт сэргээсэр байна.

Өнгөрөгч 10-р сард Малайз Пенан Манмин хэл, сонсголын бэрхшээлтэй итгэгч нарын чуулганы хариуцагч Жи Жон Хүн пастор Дани, Герман, Австри, Латви зэрэг Европийн хэл, сонсголын бэрхшээлтэй итгэгч нартай холбогдож, маш олон итгэгч хариулт ба ерөөлийг авсан юм.

Ялангуяа 10-р сарын 28нд Латви Манмин хэл, сонсголын бэрхшээлтэй итгэгч нарын

чуулган байгуулагдсаны 1жилийн ойн баярын мөргөлд ‘Итгэлийн үг’ (Еврей 5:13-14) гэсэн сэдвээр үг сургааль айлдсаны дараа эрх мэдэлт хүчтэй гар алчуураар залбирал хийж өгч, зүрхний өвчин, мөрний өвчин, нурууны өвчин эдгэрч, Германаас ирсэн нэгэн эмэгтэй итгэгч өвдөөд 3сар болж байгаа хүзүүний өвчин хөндүүрээсээ бүрэн эдгэрч Бурхандаа алдрыг өргөсөн юм (Зураг 3).



Өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Үр жимс нь зөв байгчийн үр нь амар тайвныг бүтээгчдээр амар тайванд таригддаг юм” (Иаков 3:17-18).



Манмин төв чуулганы тэргүүн пастор,
И Жей руг пастор

- Есүс Христийн нэгдсэн ариун урсгалын ерөнхий удирдагч
- Христийн сайн мэдээ сэргэлтийн холбооны ерөнхийлөгч
- Үндэсний хайрын залбирлын нэгдсэн хорооны хамтын удирдагч
- (GCN) (Жи Си Эн) Глобал Христийн телевизийн ерөнхий захирал
- (WCDN) Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбооны ерөнхий захирал
- (MIS) Манмин олон улсын библийн их сургуулийн захирал
- Нэгдсэн ариун библийн сургуулийн захирал
- Библи судлалын доктор, Теологийн хүндэт доктор
- Христийн телевиз, радиогийн албан ёсны сургаал заагч
- Чусон илбу, Жүнан илбу, Туна илбу, Хангүг илбу, Сөүл сонин Хангёорэ сонин, Кеонхян сонин, Хангүг кёнжэ сонин, Ши са ньюс, Кристиан сонин зэрэг өдөр тутмын сонин, сэтгүүлд итгэлийн амьдралын тухай байнгын нийтлэгч
- АНУ-н Нью-Йорк, Вашингтон, Балтимор, Мерилэнд, Лос-Анжелос, Хавай, Япон, Пакистан, Филиппин, Аргентин, Гондурас, Перу, ОХУ, Герман, Кени, Танзани, Уганда, Конго бүгд найрамдах улс, Израйль Иерусалим, Эстони зэрэг улс орнуудад нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан

АНУ-н Нью-Йорк хотын даргаар гурван ч удаа сонгогдсон Пеурел ла Кади нь Нью-Йорк хотын шүүхд шүүгчээр ажиллаж байх үед болсон явдал юм. Нэгэн удаа дэлгүүрээс талх хулгайлж байгаад баригдсан настай эмээгийн хэрэг дээр ажиллаж байх үед юм. Тэр эмээ гэрт нь өлсөөд уйлж байгаа хүүхдүүдийнхээ төлөө талх авсан гэж шүүх хуралд гэж хэлсэн байдаг.

Тухайн үйл явдлын тухай бүгдийг сонссон Пеурел ла Кади шүүгч 10долларийн торгуулийн шийтгэл ноогдуулангаа “Тухайн нөхцөл байдалд та бусдын эд зүйлсд гар хүрсэн үйлдэл тань хуулийн дагуу бол яалт ч үгүй таны буруу юм. Гэвч хөршийнхөө хүнд хэцүү байдлыг үл тоомсорлосон иргэнд ч хариуцлага тооцох ёстой тул би 10долларыг тань төлье” гэсэн байдаг.

Тэгээд өөрийн бүрх малгайгаа шүүхийн нарийн бичигт өгч “Энэ цугласан та бүхэн ч гэсэн над шиг торгууль төлөхийг хүсч байгаа бол ийшээ хийнэ үү” гээд малгайгаа шүүх хуралд оролцогчдын дундуур дамжууллаа. Настай эмээ торгуулийн 10доллараас гадна 47доллартай болж сэтгэл хөдлөн нулимс дуслуулан зогсож байлаа.

1. ‘Өршөөл’ ба ‘Сайны үр жимс’ хоорондын холбоо

‘Өршөөл’ хэлний толь бичиг дээрх утга нь ‘Бусдыг өрөвдөх, өршөөх’ гэсэн байдаг. Сүнс талаар бусдыг өрөвдөөд зогсохгүй, ‘Нэг хүнийг бүх тэнгэр газраас ч илүү эрхэм нандинд тооцох’ тухай хэлж байгаа юм. Хичнээн боломжгүй мэт харагдах хүнийг ч шантралгүй эцсээ хүртэл авралд хүргэх гэсэн сэтгэл юм. Үүний тулд сайхан сэтгэлийн суурин дээр бусдын оронд өөрийгөө тавих сэтгэл байх ёстой байдаг.

Ийм сэтгэлтэй болж байж хүнийг амилуулах мэргэн ухаан, авралын зам руу хөтлөх мэргэн ухааныг олох боломжтой юм. Тийм мэргэн ухаанаар л хүмүүст хүч өгч, шархалсан сүнснүүдийг эдгээх боломжтой юм. Энэ мэтчилэн Бурхан дотор энэрлийг буулгаснаар бий болох үр жимс нь “Сайны үр жимс” болж энэрэл өршөөл, сайны үр жимсийн нэгэн цогц үр дүн болдог.

Бурханы угийн сэтгэл тэр чигтээ өршөөл бөгөөд бүх хүмүүс гэмших боломжыг авч, авралд хүрдэг байна. Бурхантай мөн чанарын хувьд нэг болох Есүсийн сэтгэл ч тэр чигтээ өршөөнгүй сэтгэл бөгөөд гэмтнүүдийг дуудахаар, гэмшүүлэхээр энэ газарт ирсэн юм. Бяцлагдсан хулс мэт сэтгэлээр гэмт автсан хүнийг ч, сүүмэлзэх төдий авралын боломж нь дуусч буй хүнийг ч эцсээ хүртэл тэсч хүлээн (Матай 12:20), татвар хураагч нар, биеэ үнэлэгч нар шиг адлагдсан гэмтнүүдийг ч гэсэн Тэрээр ялгалгүй сайн мэдээг дамжуулсан юм.

Гэтэл эрх мэдэлт хүчийг л үйлдэж, зөвхөн сайн үйлсийг л хийж байсан Есүсийг эсэргүүцэж байсан хүмүүс ч байсан ба Искаротын Иуда шиг Есүсийг зарж орхисон хүмүүс ч байсан юм. Есүс ийм хүмүүсээс ч нүүр буруулалгүй эцсийн мөч хүртэл авралын боломжыг өгсөн юм.

Нэг хүнийг бүх тэнгэр газраас илүү эрхэмд үзсэн Бурханы сэтгэлээр загалмайд цовдлогдон нас барсан тул бүх хүмүүст аврал зам нээлттэй болсон юм. Түүний үнэт цусийг итгэн түшиж, аврал хүртсэн үй олон хүмүүс зөвхөн Есүсийн “Өршөөлөөр дамжуулан боловсорсон сайны үр жимс” юм.

2. Амийг өгдөг өршөөлийн мэргэн ухаан

Өршөөл гэдэг нь зүгээр л өрөвдөх өршөөх явдал биш юм. Нэг сүнсийг авралын замаар хөтлөхийн тулд уучилж, ба зэмлэж, заримдаа тусламж өгөх үе ч байна.

1) Бусдын өмнөөс ойлгох уучлалын сэтгэл

Ефес 4:32 “Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд” гэсэн байдаг.

Бурхан ба Эзэн биднийг энэрч, уучилсан шиг бид ч бие биенээ уучил гэсэн байгаа юм. Гэхдээ энэрч, уучлахын тулд бусдын өмнөөс ойлгож чадах хэрэгтэй юм. Миний хувьд огт уучлахын аргагүй юм байсан ч бусдын үүднээс ойлгож өгвөл хичнээн л бол уучилж өгөх боломжтой юм.

Жишээ нь Эзэнд итгэдэггүй нөхөр нь өөрийг нь хавчих үед нөхрийнхөө өмнөөс ойлгож өгөхийг оролддог нөхөр нь үнэхээр өрөвдөлтэй бас харамсмаар байдаг. Хавчигдаж байгаагаа өөрийнхөө нь бурууд тооцож нөхрийнхөө төлөө хайрын залбирал хүртэл гардаг. Ийм өршөөлийн залбиралд Бурхан нөхрийнх нь сэтгэлийг хөдөлгөж өгдөг. Хэлэх нэг үг ч нөхөрт нь сэтгэл хөдлөх мэргэн ухааныг өгдөг.

Итгэлтэй хүний үүднээс үнэн зөв, мэдээжийн мэт үг байсан ч итгэгч биш хүнд сайн ойлгогдохгүй байх зүйл маш их байдаг. Тиймд зөвхөн өөрийн байр сууринаас л яривал бие биетэйгээ маргаж, сэтгэл шархалж тавгүйтэх төдий юм. Бусад хүн л буруутай гэх бус, бусдын сэтгэлийг ойлгож, тэдний үүднээс бодох үед л мэргэн ухаан гардаг.

Зарим хүн сүмийн ажилтан мөртлөө аар саар шалтгаанаар эргэн тойрны хүмүүсийг эвгүй байдалд оруулдаг. Удаан хугацаанд Бурханы үгийг сонссон ч өөрчлөгдөлгүй мөн хуурч мэхэлдэг хэвээрээ л, өөрийн зөрүүд занг засдаггүй хүн, ийм тийм ярианд дуртай хүн, өөрийн хүсэл, шуналаа гүйцээх гэсэн янз бүрийн хүмүүс байдаг. Ийм хүмүүсийг харахад нэг талаар сэтгэл өвдөх үе байх ч ийм үед өмнөөс нь ойлгож, өршөөж, өнгөрөөх хэрэгтэй байдаг. Тэд ч гэсэн өөрчлөгдөх гэсэн хүсэлтэй хирэндээ Бурханы үгийн дагуу Бурханыг хайрлаж, сүмийнхээ хүч, тулгуур нь болох хүсэлтэй байдаг.

Гэсэн ч төрөлхийн, эсвэл боломж муутай, тааруу орчинд нөхцөлд өсөж бойжсоноор зүрх сэтгэлд нь үнэндий бус мэдлэг ихээр суулгагдсан байдаг тул сайнаар зүрх сэтгэлээ хүчээр сул дорой байдаг. Толгойгоороо сайныг үйлдэх ёстой гэдгийг мэддэг ч Бурханы үгээр сэтгэлээ сахиж ч чадахгүй байх үед хэн хүнээс илүүтэй өөрөө л тавгүйтдэг. Ингэж бусдын үүднээс ойлгож өгвөл тавгүйтэж адайр зан гаргаж байгаа хүн ч гэсэн хөөрхийлөлтэй, хайр хүртэм харагдаж, бусдаар дамжуулан ямарч хохирол амссан ч мөн сэтгэл бачимдсан ч тэсч тэвчин хүлээх уучилж өгөх хэрэгтэй юм.

Би сүм байгуулаад одоог хүртэл хар ухаанаар ч ойлгохын аргагүй үйл явдлууд, сүмийг хүнд байдалд оруулдаг хүмүүсүүдийг харж байсан ба Бурханы хүч нөлөөг агуу ихээр харж байсан ч хэзээ нэгэн цагт гэнэт хувирч, сүмээ эсэргүүцдэг хүмүүсийг ч харж байлаа. Тэгэх тоолонд би тэдний алдаа дутагдлыг итгэгч нарт илчилсэн үү! Огт тэгээгүй. Зөвлөгөө, зэмлэл хүлээн

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг
Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

авч чадахгүй хүнийг тэвчиж, хүлээх нь илүү дээр байх тохиолдол ч бий. Хэдийн сүмээсээ явсан хүн байсан ч өнгөрсөн явдлыг нь бусдад дэлгэхгүй байх нь хэзээ нэг цагт ирэх замыг нээлттэй орхиж байгаа хэрэг юм.

Мэдээж буруу зүйлийг шууд уучилж, зүгээр өнгөрөө гэсэн үг биш юм. Уучилна гэдэг нь бусад хүний сүнснийг аврахын төлөө байдаг. Заримдаа уучилахаас илүүтэй зэмлэж өгөх нь ч бусдыг амьдруулах үе ч байна. Зэмлэл хүлээж авалгүй тэгээд өнгөрвөл Бурханы өмнө гэмийн хана болно гэдгээ ухааралгүй мөхлийн замаар явж болзошгүй учраас тэр юм.

2) Бусдын сэтгэлийг нээх шийтгэх ууч сэтгэл

Уучлал ба шийтгэх нь эсрэг утгатай мэт харагдаж байгаа ч тийм биш юм. Өршөөл ууч сэтгэлд хамаарах шийтгэл нь хайраар сахилгажуулах, шийтгэх явдал юм. Еврей номын 12:5-8д “...Миний хүү, Эзэний сахилгажуулалтыг хөнгөн үзэж болохгүй. Тэр чамайг зэмлэх үед сэтгэлээр бүү уна. Учир нь Эзэн хайрладаг хүнээ сахилгажуулдаг юм. Тэр хүлээн авсан хүү болгоноо ташуурддаг. Та нарын тэвчдэг чинь сахилга баттай болгохын төлөө юм. Бурхан хөвгүүдтэйгээ харьцдаг шигээ та нартай тийнхүү харьцдаг. Учир нь эцэг нь сахилгажуулдаггүй хүү хаана байна? Хэрэв бүгдээрээ хүртсэн сахилга та нарт байхгүй бол та нар хөвгүүд нь бус, бутач хүүхдүүд аж” гэсэн байдаг. Өөрөөр хэлбэл Бурхан биднийг хайрладаг тул буруу юм хийх үед шийтгэх үе байдаг ч гэмийн хана нь улам хураагдсаар байвал Бурхан нүүр буруулвал шийтгэл бууж ирэхгүй байх үе байна

Зарим хүн шийтгэл, сахилгажуулалтаас зайлсхийж, өөрийн буруутай байдлаа хучиж, шалтагладаг. Эсвэл өөрийн дутагдал нь ил гарах үед шантарч гунддаг. Хэрвээ даруу сэтгэлээр өөрийн бурууг хүлээж гэмшвэл Бурхан түүний алдаа дутагдлыг дахин санах ч үгүй зайлшгүй хүнд байдал дотроос эргэж сэргээж өгдөг. Гэхдээ бусдын алдаа дутагдлын тухай мэдэж, зөвлөгөө өгөх юм уу зэмлэх үедээ өөрийн зүрх сэтгэлээ сайн ажиглах хэрэгтэй юм.

Хайраар зөвлөж байгаа мэт далдалсан ч яг үнэндээ миний зөв гэсэн байр сууринаас бусдын хатгах үг хэлэх юм уу, бардам эрдүү сэтгэлээр бусдад зааварлах, өөрийн хүссэнээр удирдах гэх ч явдал бас байдаг. Өршөөх сэтгэлгүй зөвлөгөөг бусад хүн сайн сонсдоггүй. Энэ үед өөрийг нь үл тоомсорлож байна гэж сэтгэл тавгүйрхэж, илүү хатуу үгээр бусдыг өдөөн хатгаж, зэмлэдэг хүн бас байна. Уг нь бусдыг өөрийн буруугаа өөрөө хүлээн зөвшөөрөх хэмжээний тэгж харьцах ёстой юм.

Ийм үед зэмлээгүй байсан нь илүү дээр байдаг. Хичнээн Бурханы үгийг ашиглан хэлж өгсөн ч хайр агуулагдаагүй бол сонсч буй хүнд гэмших ухаарах ивээл ирдэггүй. Бусдыг ухааруулж, сэтгэл хөдөлгөх бус харин ч сэтгэлийг нь шархдуулж, хүчээ алдахад хүргэдэг. Өөрийн алдаа дутагдлыг ухаарч, сайн хичээе гэж зүтгэсэн ч сэтгэлээр унаж тэндээ зогсонги болдог.

Тиймд бусдад зөвлөх юмуу шийтгэж зэмлэхдээ бусдын үүднээс ойлгож өгөх ууч сэтгэл дотор хийх хэрэгтэй юм. Түүний төлөө амиа ч өгч чадах хайрын сэтгэлээр залбирч, зөвлөж өгөх хэрэгтэй. Ийм сэтгэлтэй болвол шаардлагатай бол шийтгээд ч хамаагүй бусдыгаа үнэн дотор хөтлөн оруулж чадах юм. Эсрэг талын хүндээ санаа зовнин өршөөнгүй сэтгэлтэй хүн бол зэмлэхдээ ч их ухаалаг ханддаг.

Эзэн Ефес чуулганыг зэмлэх үед эхлээд сайн хийдэг зүйлийг магтаж өгдөг. Тэр магтаалийг сонсоод сэтгэлээ нээх яг тэр үед тэдний буруутай үйлдлүүдийг ухааруулж өгч үүний тухай хатуу сануулсан байдаг. Түүний дараа мөн дахин сайн чанаруудыг нь сайшааж өгсөн байдаг (Илчлэлт 2:2-6). Зэмлүүлснээс болж хүчээ алдахгүй байхын тулд магтан сайшаах зүйлийг үлдээж байгаад зэмлэж өгөөд дараа нь дэмжиж урам өгдөг байна. Үүний нэгэн адил хэн нэгэнийг зэмлэх үедээ Эзэн шиг “Бусдын сэтгэлийн нээх ухаан”-д суралцаж сайн ашигладаг байх хэрэгтэй юм.

3) Бусдад тус дэм болдог өршөөнгүй сэтгэл

Өршөөнгүй сэтгэл байгаа бол хүнд хэцүү

байдалд байгаа хүмүүсийг хараад өрөвдөлтэй юмаа гэж бодоод өнгөрөх бус бодит тусламж дэмжлэг хэрэгтэй юм. 1 Иохан 3:18д “Бяцхан хүүхдүүд ээ, бид үг хэлээр бус, ажил үйлс, үнэнээр хайрлагсаа” гэсний дагуу жинхэнэ өршөөнгүй сэтгэл бол ажил үйлс ба үнэнээр бусдад тусладаг.

Юуны түрүүнд сайн мэдээг мэдэхгүй хүмүүст өршөөнгүй хандах хэрэгтэй байдаг. Хавчлага авах юм уу, тэр байтугай амийн аюулд өртсөн ч сайн мэдээг дамжуулах нь өршөөнгүй сэтгэл байгаагийн шинж юм. Мөн унаж дампуурсан хүн, өвчтэй хүн, нийгмээс гадуурхагдсан хүмүүст өршөөнгүй сэтгэлээр харж хандах хэрэгтэй юм. Ингэж ажил үйлс ба үнэнээр үйлчлэх үед Бурхан суулгаснаас нь ч илүү арвин их ерөөлөөр буцаан төлж өгдөг (Лук 6:38). Тиймээс бодит тусламж бол мэргэн ухаан юм.

Үйлс номын 9-р бүлэгт үзвэл Иоффа амьдардаг Табита гэх эмэгтэйн тухай гардаг. Тухайн үед ихээр хавчигдан маш хүнд байдалд ч Табита өөрийн амийг хайрлалгүй хичээнгүйлэн сайн мэдээг тараадаг амьдарлаар амьдарсан юм. Тэрээр эхлээд өрөвдөлтэй хүнд хэцүү хүмүүст тусалдаг байв. Табита өвчин тусаж, үхэхэд түүнээс тусламж авч байсан хүмүүс тэр эмэгтэй амилуулж өгөөч гэж Бурханаас гуйдаг.

Эцэст нь Петр Иоффа хавьд явж байгаа сураг дуулаад хүн явуулж, хүрч ирээч хүсэлт явуулдаг. Нэлээд удаж байж Петр тэнд очиход бэлэвсэн эмэгтэйчүүд үйллалдан Табита өөрсдийнх нь төлөө юу хийж өгсөн талаар ярьж түүний хийж өгсөн хувцсыг үзүүлдэг. Тэрээр сайн үйлс ба тусламж нь Бурханд хүрч Петрийн залбирлаар дахин амьдрах ерөөлийг авсан юм.

Нэг талаар тусламж нь Бурханыг баярлуулах үйлс хэдий ч туслах хүнээ сайн ялгах хэрэгтэй юм. Галат номын 6:10д “Тиймээс бид боломж завшаантай байх үедээ бүх хүнд, юуны түрүүнд итгэлийн гэр бүлийн гишүүдэд сайныг үйлдэцгээе” гэсэн тул боломжтой л бол итгэлийн гэр бүлдээ туслах хэрэгтэй юм. Гэтэл боломж хэр тааруу хүмүүсийн дотор, архи болон мөрийтэй тоглоомд автаж, ажил хийдэггүй тохиолдолд тусласан ч ерөөл авах боломжгүй юм. Мөн Бурханд итгэдэг гэсэн мөртлөө ёс бусыг үйлддэг, тэгж байгаад хүнд байдалд орсон хүмүүст өршөөнгүй хандаж, хөрөнгө мөнгө зээлүүлэх, хамтын бизнес хийсэн ч Бурханы өмнө зохистой биш тул харин ч хамтдаа хэцүү байдалд орж болзошгүй юм. Хуучин гэрээнд гардаг Ионад тусалсан хүмүүс шиг юм (Иона 1-р бүлэг).

Уучлал ба зэмлэл ч хүмүүсийг аврахын төлөөх зорилгоор хийдэг шиг тусламж ч мөн хүмүүсийг

аврахын төлөө байдаг. Хэрэв нөхцөл байдлыг сайн ялгалгүй шууд туслаад байвал харин эсрэгээр бусдад хохирол болж болзошгүй юм. Тэрээр тусламж авсан эд зүйлээрээ гэмт үйлдэл хийвэл яаж жинхэнэ тусламж болох вэ?

Ерөнхийдөө би ёс бусыг үйлдээд соригдож байх үедээ юмуу, хуурч мэхэлдэг хүнийг мэдсээр байж туслах үе байдаг. Тэр нь түүнд гэмших боломж өгч, амьдрах зам мөрийг хайж байгаа хэрэг юм. Мэдээж тэгсэн ч эцсээ хүртэл гэмшилгүй Бурханаас холдон явдаг хүн ч бас бий. Ийм үед ч Бурхан хүмүүсийн төлөөх итгэл, хайр, тусламжаар өршөөлийн үрийг тарьдаг гэдгийг санаж ингэсэн хүн бүрийг ерөөлөөр хариулж өгдөг.

3. Сайны үр жимсээр дүүрэн мэргэн ухаан

Эзэн дотор өршөөнгүй сэтгэл арвин их болвол зайлшгүй үзэсгэлэнтэй үр жимс гаргадаг. Юуны түрүүнд үй олон хүмүүсийг аврал хөтөлж, “Үнэт авралын үр жимс”-г олдог. Мөн өршөөнгүй сэтгэлээр ханддаг хүн нь өөрийн сэтгэлдээ ч сайны үр жимс гаргадаг.

Хорон муу нэгэнд эцсээ хүртэл сайнаар хандах, тэвчээр ба хайрын залбирлаар Бурханы өмнө өргөгдөх анхилуун үнэр нь бүгд үр жимсд хамаарна. Ийм сайны үр жимсээр энэ газарт төдийгүй тэнгэрийн оронд ч агуу алдрыг эдлэх болдог.

Бидний Аврагч Эзэн болсон Есүс төсөөлөхийн аргагүй агуу өршөөл энэрлээр үй олон үр жимсийг хурааж авсан юм. Мөхөхөөс аргагүй байсан сүнснүүдийг өрөвдөн, өршөөн хэлтрүүлж, загалмайн зовлонг биеэрээ туулсан тул Түүний үр нөлөөгөөр тоо тоймшгүй үй олон хүмүүс авралд хүрсэн юм. Загалмайд уруугаа харж цовдлогдох хүртлээ сайн мэдээг тараасан элч Петр, аяндын хөвгүүн гэж дуудагддаг байсан ч хайрын элч болсон Иохан зэрэг библид гарч буй хүмүүсээс гадна маш олон үр жимс гарсан юм. Бид ч мөн Эзэний энэрэл өршөөлөөр бий болсон сайны үр жимс юм.

Хайрт итгэгч та бүхэн,

Бурхан өршөөл ба сайны үр жимсээр дүүрэн бөгөөд нэг нэг хүнийг хайраар халамжилж, өгөхийг хүсдэг (Матай 9:13; Еврей 13:16). Ийм сэтгэлийг нь бид ухаарч, ажил үйлс ба үнэнээр хөршөө хайрлан, шархалсан нэгэнийг тайтгаруулж, тусалж өгөн, Бурханыг баярлуулж, зүрх сэтгэлийн хүсэл мөрөөдөлдөө хүртэл хариулт авсан (Дуулал 37:4) мэргэн ухааныг бүрэн эзэмшихийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Ниранут Тананчая эгч дүү (21нас, Тайланд Чиан рай Манмин сүм)



Чиан рай Манмин сүмд “Солонгос хэлний сүүлл”-д сууж байхдаа би санаандгүй байдлаар И Жей руг тэргүүн пасторын

үе үе юм мөргөж унадаг байлаа. Малын эмч үзээд удамшлийн гаралтай нүдний болор цайралт гэсэн бөгөөд зайлшгүй хагалгаа хийлгэх ёстой гэсэн ба тэгээд төгс эдгэрч чадахгүй гэсэн юм.

“Бурхан манай тугалын нүдний болор цайх өвчнийг эдгээж өгсөн”



сургаалийг сонссон юм. Үзэн ядалт, атаархал, худал хэлэх нь бүгд гэм нүгэл гэсэн бөгөөд эдгээрийг хаях аргуудыг хүртэл тайлбарлаж өгсөн сургаалийг сонсоод миний сэтгэл ихэд хөдлөн 2017оны 5-р сард манмины итгэгч болсон юм.

2018оны 3-р сард би маш гайхалтай

Бурханы хүч нөлөөг мэдэрсэн юм. Аав ээжийн минь тэжээдэг үхэр тугалсан ба тэр тугалын зүүн нүд нь цайрсан байсан бөгөөд бараг хараагүй шахуу байдаг. Тийм болохоор сайн алхаж чадахгүй тул

Б и и х сургуулийнхаа о й р о л ц о о а мь д а р д а г болохоор энэ тухай сонсоод тэр тугал их өрөвдөж, сэтгэл жоохишон тавгүйхэн ээж аав дээр очсон юм. Тэгээд тэргүүн пасторын залбирал хийж өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс 19:11-12)-аар тугал дээрээ тавьж залбирал хийж өгсөн юм. 5өдрийн дараа аав надад нэгэн баярт мэдээ дуулгасан ба гайхалтай нь тугалын цайрсан нүд нь эдгэрч, одоо сайн алхаж дэвхцдэг болсон гэсэн юм. Халлелуяа!



“Зөвхөн сайныг үйлдэхэд сарын борлуулалт төлөвлөснөөс давсан юм”

Сун Вон гю туслагч
(50нас, 3-р их бүлэг 26хэсэг)

Би Кёонги ду аймгийн Яанжү хотод 20иод жил жууцайны тариалан эрхэлж байна. 2018онд 7-р сард ийм явдал болсон юм. Нийт тариалангийн талбайн 1000гаруй пёон (Солонгосын газрын хэмжүүр)-г эзэмшдэг газрын эзэн “Газраа зарах гэрээ хийсэн болохоор үр тариагаа бүрэн хурааж, хүлэмжнүүдээ буулгаарай” гэсэн юм.

Уг нь гэрээний хугацаа нь 2019оны 12-р сар хүртэл боловч хэдэн жилийн турш зарагдахгүй байсан газар сайн таатай нөхцөлөөр зарагдах болсон тул яаж ч чадахгүй болсон юм. Нөхцөл байдал төвөгтэй байсан ч би хэдэн өдрийн хугацаа өгвөл би хариугаа хэлье гээд эхлээд үүнд “Бурханы хүсэл байгаа юм биш биз” бодож тунгаасан юм.

Ертөнцийн аргаар энэ асуудлыг шийдэх гэж магадгүй гомдол зарга үүсгэж, нэхэмжилбэл миний талд байх ч тэгвэл бие биетэйгээ муудалцаж, урьдах шигээ өөрийн үүднээс зүтгэж байгаад уурлавал Бурхандаа эвгүй байдлыг үзүүлэх мэт болох гээд байлаа.

Библид бичигдсэн Бурханы үгэнд өөрийн эрх ашгийг хайлгүй бусдын эрх ашгийг хайж, үргэлж сайныг үйлд гэсэн байдаг. Ялангуяа И Жей руг тэргүүн пастораар дамжуулан ямар нөхцөлгүйгээр



гүйж буй хөршдөө өгдөг бас дахин өгдөг хайрын сэтгэлийг харж ирсэн тул “Би ч сайнаар дийлэх болно” гэж сэтгэлдээ шийдсэн юм. Сайныг үйлдвэл Бурхан зайлшгүй нөлөөлөх болно гэдэгт итгэл төрсөн тул шууд бусдын хүсэж байгаа тал дээр нийцүүлж өгөхийг хүссэн юм.

Тэгтэл 8-р сарын энхний долоо хоногт талбайн эзэн газар зарах гэрээ цуцлагдсан ба үргэлжлүүлэн тариагаа таривал сайн байна гэсэн мэдээ сонсогдлоо.

Тэгээд өмнө тэгж эвгүй харьцсандаа уучлалт гуйж, энэ тал дээр асуудал үүсгээгүйд баярлалаа гэсэн юм. Тариалан эрхлэхэд янз бүрийн бэрхшээл тулгардаг ч тэр болгонд Бурхандаа найдан түшиглэн асуудлаас зайлсхийх аргыг нээж өгсөн ба энэ удаад ч миний залбиралд хариулж өгсөн юм.

Би жил бүр жууцайны тариалангийнхаа төлөө эхний ачилт болгондоо тэргүүн пасторын залбирлийг авсаар ирсэн. 2018онд ч мөн л тэгсэн ба 100жилийн турш болоогүй их халууны улмаас жууцайны тариаланд ноцтой хохирол учруулж болзошгүй байсан ч Бурхан сахин хамгаалж өгснөөр гантай байсан ч тохиромжтой цаг үед бороог оруулж өгч байлаа.

Үүний үр дүнд өмнөхөөс харин ч илүү ургацын гарц сайжирч, дунджаар сард 30саяын борлуулалтын төлөвлөгөө байсан бол 2018оны 8-р сард 40сая болж өссөн юм. 20жилийн турш ийм явдал анх удаа тохиосон юм. Халлелүяа!

Энэ мэт ерөөж өгсөн Бурхан Аавдаа бүх л талархал ба алдрыг өргөе. Цаашид ч хайрын Бурхан ба Эзэнийг л түишж библии нүгийн дагуу дуулгавартай дагаснаар хамгийн үзэсгэлэнтэй газар Шинэ Иерусалим руу эрч хүчтэй орох болно.

“Ходоодны архаг үрэвсэлт хүнд өвчнөөсөө төгс эдгэрч, эд хөрөнгийн ерөөл авсан”

Наталя Коронаду итгэгч (34нас, Перу Манмин сүм)



Наталя Коронаду эгч дүү (зүүн талаас 2дах нь) ээж болон ах нарын хамт

Би 2015оны сүүлчээр ходоодны үрэвсэлт өвчнөөр өдөр бүр маш хүчтэй өвдөж, ялангуяа шөнө болгон ус ууж ходоодны өвчнөө аргадаж хэд хэдэн удаа босдог байлаа. Өвчнийхөө гол шалтгаан мэдэхээр эмнэлэгт очин шинжилгээ хийлгэтэл хелико бактериас үүдэлтэй архаг ходоодны үрэвсэл гэсэн оноштой болов.

Ингээд миний хувьд итгэлээрээ эдгэрэл олохыг хичээсэн ч хэдэн сар өнгөрөөд өвчин дахин сэдэрч, харин бүр илүү хүчтэй өвддөг болов. Тэгээд 2016оны 6-р сард дахин шинжилгээ өглөө. Хариу нь ходоодны үрэвсэл маань өмнөхөөс илүү хүндэрсэн ба хелико бактерийн хэмжээ улам ихэссэн байсан юм. Би эмнэлэгээс зөвлөсөн эмийг маш сайн уусан ч эмийн үр дүн түр зуур үйлчлэх ч өвчин хөндүүр нь туйлдаа хүрч байлаа.

Тэр л үед би магадгүй би Бурханы өмнө зохисгүй үйлдэл үйлс юу билээ гэж эргэж харах болсон юм. Юуны түрүүнд үр хүүхдээ цэвэр зүрх сэтгэлтэй болоод Бурхан Аавыгаа дуурайх ёстой гэдгийг ухаарсан үе байлаа. Өвчин зовиур үргэлжилсээр байсан ч Бурхан Аавдаа яадаг ч байсан талархах гэж хичээж байлаа. Тэгээд залбирангаа тэр хугацаанд намайг сахин хамгаалдаггүй гэж тавгүйтэж байсан сэтгэл ба бардам сэтгэлээ гэмшсэн юм.

2017оны 8-р сарын 3нд Манмин бүх итгэгч нарын зуны цуглаанд И Жей руг тэргүүн пасторын залбирлаар эдгэрэл авъя гэсэн сэтгэлээр өөрийн өвчний оношийг баталгуужуулахаар ходоодоо дурандуулсан юм. Гэтэл ходоодний үрэвсэл бараг эдгэрсэн төдийгүй хелико бактери ч бараг харагдахгүй болсон байна гэсэн

юм. Бурхан миний чин сэтгэлээрээ гэмшсэн үйлдэлд маш хурдан хариу өгч эдгээж өгөн, үнэхээр Бурханы хүссэн гэмшил байсан тул түүгээр дамжуулан зүрх сэтгэл минь өөрчлөгдсөн байлаа.

Манай Перу Манмин сүм нь Солонгостой цагын ялгаа нь улмаас бичлэгээр Манмин бүх итгэгч нарын зуны цуглаанд оролцсон юм. 8-р сарын 7ны өдөр Зуны цуглааны эхний өдөр, тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг авсаны дараа би цэвэрхэн эдгэрч эв эрүүл болсон төдийгүй ажил дээрээ цалин 70% нэмэгдэх ерөөл хүртэл авсан юм. Халлелүяа!

Бурханы жинхэнэ үр хүүхэд болгон өөрчилж, хамгийн үзэсгэлэнтэй тэнгэрийн орон Шинэ Иерусалимд орох хүртэл хөтөлж өгдөг Бурхан Аав, Эзэндээ бүх л талархал ба алдрыг өргөе. Эзэн дотор хайрт гэр бүлийнхэнтэйгээ залбирч аз жаргалтай итгэлийн амьдралаар удирдаж өгсөн тэргүүн пастортаа талархал өргөе.

Эмчийн магадлагаа

DIAGNOSTICO: **HELIcobACTER PYLORI (++++)**

RESULTADO: **NEGATIVO (-)**

Эдгэрсэн байдал

▲ Хүчтэй өвдөлт зовиур бүхий архаг ходоодны үрэвсэлээ чин сэтгэлээсээ гэмшихэд маш хурдан эдгэрсэн нь.

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь			залбирал цагийн хуваарь			Манай хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр
Мөргөл	Цаг	Ангилал	Цаг	Удирдагч	Манай хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр	
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч	Чуулганы утас: 7000-3707	
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30					
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч	Чуулганы ахлагчийн утас: 8870-3712	
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30					
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч	E- шуудан : power3712@gmail.com	
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00					
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00					

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин